

“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 04-ний өдөр

№01

Өвөрхангай аймаг

Компанийн 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, 94 дүгээр зүйлийн 7 дах заалт, компанийн дүрмийн 6.3.6 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн “Баянтээг” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Баянтээг” ХК-ийн 2018 оны жилийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай. Түүнчлэн компанийн 2018 оны санхүүд хуулийн шаардлагаар бус хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр санхүүгийн тайлангийн аудитыг олон улсад үйл ажиллагаа явуулдаг, нэр хүнд бүхий хөндлөнгийн компаниудаас сонгож дахин хийлгэх, холбогдох гэрээ хэлцлийг байгуулах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхийг ТУЗ-ийн дарга (О.Батжаргал)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



/А.ИШДОРЖ/

“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 04-ний өдөр

№02

Өвөрхангай аймаг

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн “Баянтээг” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. “ТУЗ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна” гэсэн дүрмийн өөрчлөлтийн төслийг хувьцаа эзэмшигчид дэмжээгүй тул Компанийн дүрмийн 7.2 дахь заалтыг хэвээр үлдээсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



/А.ИШДОРЖ /

“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 04-ний өдөр

№03

Өвөрхангай аймаг

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийг үндэслэн “Баянтээг” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Орон нутгийн өмчийн төлөөллийн зүгээс хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийн талаар зөвшилцөөгүй байгаа тул эл асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн дараачийн хурлаар хэлэлцүүлсүгэй.
2. Үүнтэй холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулхыг ТУЗ-ийн дарга (О.Батжаргал)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



ТА.ИШЦОРЖ/